

МОНГОЛ УЛСЫН СТАНДАРТ

Ангилалтын код: 13.020.10

Байгаль орчны удирдлага- Амьдралын мөчлөгийн үнэлгээ - Өгөгдлийн баримт бичгийн хэлбэр	MNS ISO/TS 14048:2004
Environmental management – Life cycle assessment- Data documentation format	

Стандартчилал, Хэмжилзүйн Үндэсний Зөвлөлийн 2004 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн 63 дугаар тогтоолоор батлав.

Энэхүү стандарт нь 2005 оны 02 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн хүчинтэй.

1 Хамрах хүрээ

Энэхүү техникийн шаардлага нь амьдралын мөчлөгийн үнэлгээ, амьдралын мөчлөгийн задлан шинжилгээний өгөгдлийг солилцох, ойлгомжтой тодорхой баримтжуулахад хэрэглэх өгөгдлийн баримт бичгийн хэлбэрийн бүтэц, шаардлагыг тодорхойлох ба холбогдох мэдээллийг тодорхой тусгаснаар өгөгдлийн цуглуулалт, тооцоолол, чанарын тайлан, өгөгдлийн баримтжуулалтыг тогтооно.

Өгөгдлийн баримт бичгийн хэлбэр нь тус бүртээ тайлбар тодорхойлолт бүхий өгөгдлийн талбаруудад өгөгдлийн баримт бичгийг хуваарилах шаардлагыг тодорхойлно. Түүнчлэн өгөгдлийн баримт бичгийн хэлбэрийн бүтэц нь өгөгдлийн талбарыг тодорхойлно.

Энэ стандартыг асуулгын хэлбэр ба мэдээллийн системийн бүтэц, тодорхойлолтонд хэрэглэнэ. Мөн үүнийг байгаль орчны өгөгдлийн удирдлагын бусад асуудалд хэрэглэж болно.

Уг техникийн шаардлага нь өгөгдлийн баримтжуулалтын бүрэн байдалд тавигдах шаардлагыг агуулахгүй. Өгөгдлийн баримт бичгийн хэлбэр нь аливаа программ хангамж болон өгөгдлийн сангаас тусдаа байна.

Энэ техникийн шаардлага нь өгөгдлийг боловсруулах буюу үзүүлэхэд ямар нэг тусгай дараалсан, график буюу журмын асуудлыг шаардах эсвэл амьдралын мөчлөгийн үнэлгээ ба амьдралын мөчлөгийн задлан шинжилгээний өгөгдлийн тусгай загварын аргачлалыг үзүүлэхгүй.

2 Норматив ишлэл

Дараахь норматив баримт бичиг нь энэхүү бичвэрт иш татах замаар тус олон улсын стандартын үндэслэл болох зүйлүүдийг агуулсан болно. Огноо бүхий иш таталтын хувьд тэдгээр нийтлэлийн дараагийн хэвлэл буюу нэмэлтийг хэрэглэхгүй байж болно. Гэсэн хэдий ч энэхүү олон улсын стандартад үндэслэн гэрээ хийх талууд доор заасан норматив баримт бичгийн хамгийн сүүлийн хэвлэлийг ашиглах боломжийг судалж үзнэ. Огноо заагаагүй иш таталтын хувьд иш татагдсан норматив баримт бичгийн хамгийн сүүлийн хэвлэлийг хэрэглэнэ. ОУСБ (ISO) болон ОУЦТК (IEC)-ын гишүүн байгууллагууд хүчин төгөлдөр байгаа олон улсын стандартуудын бүртгэлийг хадгална.

MNS ISO/TS 14048:2004

ISO 8601:2000, Өгөгдлийн бүрэлдэхүүн ба солилцох хэлбэр-Мэдээлэл солилцоо-Огноо ба хугацааны тодорхойлолт

MNS ISO 9000:2001 Чанарын удирдлагын тогтолцоо- Суурь асуудал, тайлбар толь

MNS ISO 14040:2001 Байгаль орчны удирдлага- Амьдралын мөчлөгийн үнэлгээ-Хамрах хүрээ, зарчим

MNS ISO 14041:2001 Байгаль орчны удирдлага- Амьдралын мөчлөгийн үнэлгээ-Зорилго, хамрах хүрээг тодорхойлох ба задлан шинжлэх цэс

MNS ISO 14042:2002 Байгаль орчны удирдлага- Амьдралын мөчлөгийн үнэлгээ – Амьдралын мөчлөгт нөлөөлөх байдлын үнэлгээ

MNS ISO 14043:2002 Байгаль орчны удирдлага- Амьдралын мөчлөгийн үнэлгээ-Амьдралын мөчлөгийн утгыг тайлбарлах

3 Нэр томъёо, тодорхойлолт

Тус техникийн тодорхойлолтонд MNS ISO 14040, MNS ISO 14041, MNS ISO 14042, MNS ISO 14043-ын дараахь нэр томъёо, тодорхойлолтыг ашиглана.

3.1 Өгөгдлийн эх үүсвэр

Өгөгдлийн гарал үүсэл

3.2 Өгөгдлийн төрөл

Өгөгдлийн шинж чанар

Жишээ: нэгж, тоо, богино холбоо, бичиг, логик

3.3 Өгөгдлийн талбар

Онцгой өгөгдөл бүхий тодорхой өгөгдлийг агуулагч

3.4 Өгөгдлийн баримт бичгийн хэлбэр

Өгөгдлийн баримт бичгийн бүтэц

Тайлбар: Энэ нь өгөгдлийн талбар, түүний хэсгүүд ба тэдгээрийн харилцан уялдааг агуулна.

3.5 Төлөөлөл

Өгөгдөлд тусгасан хүн амын сонирхлын зэрэглэлийн чанарын үнэлгээ

1-р тайлбар Газарзүй, цаг хугацаа, технологийн нууц байдлыг агуулна.

2-р тайлбар MNS ISO 14041:2001-ын 5.3.6-ийг үзэх.

3.6 Нэрлэвэр

Албан ёсны нэр ба тогтмол нэг аргаар өгөгдлийг ангилах

3.7 Өгөгдлийн чанар

Тогтоосон шаардлагад тохирох боломжийг харуулах өгөгдлийн шинж чанар (MNS ISO 14041:2001)

3.8 Нэгж үйл явц

Аливаа үйлдвэрлэлд хамаарах амьдралын мөчлөгийн үнэлгээний үйл явцад өгөгдлийг цуглуулж болох уг бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн хамгийн бага хэсэг (MNS ISO 14040:2001)

3.9 Үйл явц

Оролтыг гаралт болгон хувиргах аливаа үйл ажиллагаа (MNS ISO 9000:2001)

3.10 Бүтээгдэхүүний үйлдвэрлэл

Нэг буюу хэд хэдэн тодорхой функцийг гүйцэтгэж буй нэгж үйл явцтай холбоо бүхий материаллаг болон эрчим хүчний хэмнэлтийн холбогдолтой цогцолбор ажиллагаа (MNS ISO 14040:2001)

Тайлбар: Бүтээгдэхүүн гэсэн ойлголтод зөвхөн бүтээгдэхүүний тогтолцоо төдийгүй үйлчилгээний тогтолцоог оруулан тооцно.

3.11 Амьдралын мөчлөг

Түүхий эд, эсхүл байгалийн баялгийг худалдан авч, боловсруулалтаас эхлэн хаягдал бүтээгдэхүүн хүртэлх бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн үе шатны дэс дараалал, харилцан шүтэлцээт холбоо (MNS ISO 14040:2001)

3.12 Стандарт урсгал

Функциональ нэгжээр үүргийг бүрэн биелүүлэхэд илэрхийлсэн, тухайн бүтээгдэхүүний тогтолцоо дахь үйл явцтай холбоо бүхий гаралтын шаардагдах хэмжүүр (MNS ISO 14041:2001)

3.13 Өгөгдөл хариуцагч

Өгөгдлийг цуглуулж, баримтжуулах үүрэгтэй байгууллага эсхүл хувь хүн

3.14 Өгөгдөл гаргагч

Өгөгдлийг шинэчлэн эмхэтгэх, үйл явцыг загварчлах үүрэгтэй байгууллага эсхүл хувь хүн

3.15 Өгөгдөл баримтжуулагч

Өгөгдлийг өгөгдлийн баримт бичгийн хэлбэрт оруулах үүрэг бүхий байгууллага эсхүл хувь хүн

4 Хэлбэрт оруулах, тайлан гаргах

4.1 Хэлбэрт оруулах

Өгөгдлийн баримт бичгийн хэлбэрийн өгөгдлийн талбарт мэдээллийг оруулах нь өгөгдлийг хэлбэрт оруулахаас шалтгаална. Үүнд:

- Өгөгдлийн баримт бичгийн хэлбэрийн нэр томъёонд эх мэдээллийг хөрвүүлэх ба үнэлэх
- Өгөгдлийн баримт бичгийн хэлбэрт тохируулах
- Өгөгдлийн баримт бичгийн хэлбэрийн өгөгдлийн талбарт тохируулсан мэдээллийг оруулах

Эх мэдээллийг хэлбэрт оруулахад дараахь шаардлага тавигдана. Үүнд:

MNS ISO/TS 14048:2004

- Өгөгдлийн баримт бичгийн хэлбэрийн зохих өгөгдлийн талбарт мэдээллийг оруулах
- Өгөгдөл баримтжуулагч нь байгаль орчны ач холбогдолтой бүрдүүлээгүй баримтын үйл явцад холбогдох бүх өгөгдлийг зохих ёсоор дамжуулах ба ямар нэгэн алдаа гараагүй болохыг батлах ёстой. Орхигдсон буюу сайжруулсан мэдээлэлтэй холбогдуулан баримтжуулалт, баталгаажуулалт хийнэ.
- Ялгаа нь тэг утга ба хоосон (хоосон өгөгдлийн талбар) 2-ын хооронд байвал зохино.
- Янз бүрийн үйл явц, шинэчлэлийн баримт бичгийг дугаар ба хэвлэлийн дугаарын хамт тодорхойлох ёстой.

4.2 Тайлан гаргах

Үйл явцын талаарх мэдээллийг уг стандартад тусгасан өгөгдлийн баримт бичгийн хэлбэрт оруулснаар тайлан хэмээх баримт бичиг гарна.

В хавсралтад өгөгдсөн жишээ нь тайлангийн жишээ болно. Хоосон өгөгдлийн талбарыг заавал дурдах шаардлагагүй.

Уг техникийн шаардлага нь баримт бичгийн бүрэн байдалд тавих шаардлагыг агуулахгүй. Энэ нь өгөгдлийн баримт бичгийн хэлбэрийг янз бүрийн нэгдсэн тайлангийн тодорхойлолтод ашиглах боломж олгоно. Нэгдсэн тайлан бүр баримтжуулсан өгөгдлийн хэрэглэгчдэд шаардлагад нийцсэн өгөгдлөөр мэдээлэл өгөхөд тусална. Хэрэв шаардлагатай бол нэмэлт өгөгдлийн баримт бичгийн хэлбэрийг тайланд тусгаж болно.

5 Өгөгдлийн баримт бичгийн хэлбэрийн тодорхойлолт

5.1 Ерөнхий зүйл

Энэ бүлэг өгөгдлийн баримт бичгийн хэлбэрийн ерөнхий зохион байгуулалтыг харуулах ба тусгай нарийвчилсан шаардлагын жагсаалт болно.

Энэ бүлэгт өгөгдлийн баримт бичгийн хэлбэрийн салбар хэсгүүдийг тодорхой өгөгдлийн талбарт ангилна. Өгөгдлийн талбар бүр нь бичгэн ба зарим тохиолдолд онцгой нэр эсхүл тоон өгөгдлийг агуулна. Өгөгдлийн талбар бүрийн хөрвүүлэлтийг А хавсралтад товч бичлэгээр тусгайлан үзүүлсэн байна. Уг бүлгийн бүтэц нь янз бүрийн өгөгдлийн талбаруудын хоорондын холбоог харуулна. А хавсралтад электрон байдлаар хэрэгжүүлэх шаардлагыг үзүүлсэн.


Өгөгдлийн баримт бичгийн хэлбэрийг хэрэглэх жишээг В хавсралтад цаасан өгөгдлийн жишээгээр үзүүлсэн.

Хавсралтууд дах харгалзах хүснэгтийн дугаарыг уг бүлэгт үзүүлсэн өгөгдлийн талбар бүрийн ард заасан. Жишээ нь: үйл ажиллагааны нөхцөл (1.1.6.5). Мөн 7-р бүлэгт үзүүлсэн тодорхой нэрлэвэрүүдийн харгалзах дугаарыг агуулна. Жишээ нь: 7.3-р нэрлэвэр

Өгөгдлийн баримт бичгийн хэлбэр нь дараах гурван хэсгээс бүрдэнэ:

- Үйл явцын хэсэг: үйл явцын утга, оролт, гаралт
- Загварчлах, батлах хэсэг
- Удирдлагын мэдээллийн хэсэг

Үйл явцын өгөгдлийн баримт бичгийг 1-р загварт үзүүлэв.



1-р загвар- Өгөгдлийн баримт бичгийн хэлбэрийн талаархи ойлголт

5.2 Үйл явц

5.2.1 Ерөнхий зүйл

Үйл явцын цогц өгөгдлийн талбар нь техникийн нарийвчилсан баримт бичиг, түүний тоо хэмжээний үзүүлэлт бүхий загварчилсан үйл явцын өгөгдөл, баримтжуулалт болон хүчин төгөлдөр загварын шалгуурыг хамарна.

Үйл явц (1) нь 2 хэсгээс бүрдэнэ.

- Үйл явцын тодорхойлолтын (1.1) цогц өгөгдлийн талбар
- Оролт, гаралтын (1.2) цогц өгөгдлийн талбар

5.2.2 Үйл явцын тодорхойлолт

Үйл явцын тодорхойлолт нь нэгж үйл явц буюу нэгж үйл явцын хослолыг үзүүлнэ. Үүнд: нэр, бүтэц, техникийн хамрах хүрээ гэх мэт орно.

Жишээ нь:

- Нэгж үйл явц
- Нэгж үйл явцын аливаа нэгдэл
- Технологийн бүтээл: хамгийн боломжгүй болон боломжтой технологийг үзүүлэх нэгж үйл явцын загвар г.м

Үйл явцын тодорхойлолт нь сонгосон тархалтын горимоос ангид байна. Тархалтын горимыг загварчлах болон батлах хэсэгт үзүүлсэн.

Үйл явцын тодорхойлолт нь дараах зүйлсээс бүрдэнэ. Үүнд:

- a) Үйл явцын нэрийн (1.1.1) өгөгдлийн талбар
- b) Үйл явцын ангилалын (1.1.2) өгөгдлийн талбарыг дараахь зүйлсээр илэрхийлнэ:
 - Хоёрдмол утгагүй нэрийн (7.1-р нэрлэврийн 1.1.2.1) өгөгдлийн нэг талбар
 - Нэрлэвэрийн тодорхойлолт (заалт)-ын (1.1.2.2) өгөгдлийн нэг талбар

MNS ISO/TS 14048:2004

с) Өгөгдөлтэй холбоотой тоологдох тодорхойлолт (заалт)-ын (1.1.3) өгөгдлийн талбар. Жишээ нь: үйл ажиллагааны нэгж буюу стандарт урсгал:

- Төрөл (7.3-р нэрлэврийн 1.1.3.1)-ийн өгөгдлийн талбар
- Нэр (1.1.3.2)-ийн өгөгдлийн талбар
- Нэгж (7.3-р нэрлэврийн 1.1.3.3)-ийн өгөгдлийн талбар
- Дүн (1.1.3.4)-ийн өгөгдлийн талбар

d) Үйл явцын техникийн салбарын (7.3-р нэрлэврийн 1.1.4) товч өгөгдлийн талбар

e) Нэгдлийн төрлийн өгөгдлийн нэг талбар (7.2-р нэрлэврийн 1.1.5)

f) Үйл явцын технологийн (1.1.6) хэрэглэх боломжийг харуулсан технологийн нэг цогц өгөгдлийн талбарыг дараахь зүйлээр илэрхийлнэ:

- Технологийн товч тодорхойлолт (1.1.6.1)-ын өгөгдлийн талбар
- Техникийн салбар, үйл ажиллагаа (1.1.6.2)-ны өгөгдлийн талбар
- Технологийн зураг (1.1.6.3)-ийн гэсэн өгөгдлийн талбар (бүтээгдэхүүний тогтолцоог нарийвчлан үзүүлэхэд хэрэглэхгүй)
- Үйл явцын хүрээний (1.1.6.4) өгөгдлийн талбарыг (тусдаа баримтжуулсан үйл явцуудын нэгдэл байдлаар баримтжуулах үед хэрэглэнэ) дараахь зүйлсээр илэрхийлнэ:

- o Хамрагдах үйл явцын (1.1.6.4.1) өгөгдлийн талбар
 - o Завсарын бүтээгдэхүүний урсгалын (1.1.6.4.2) өгөгдлийн талбар.
- Үүнд:

I) Завсарын бүтээгдэхүүний эх үүсвэр үйл явцын (1.1.6.4.2.1) өгөгдлийн талбар

II) Эх үйл явцын завсарын бүтээгдэхүүний нэр өгөх оролт, гаралтын эх үүсвэрийн өгөгдлийн талбар (1.1.6.4.2.2)

III) Завсарын бүтээгдэхүүний нэр өгөх оролт, гаралтын байрлалын өгөгдлийн талбар (1.1.6.4.2.3)

IV) Завсарын бүтээгдэхүүний байрлалын үйл явцын өгөгдлийн талбар (1.1.6.4.2.4)

- Үйл ажиллагааны нөхцлийн тодорхойлолтын өгөгдлийн талбар (1.1.6.5)

- Математикийн загварын цогц өгөгдлийн талбарыг дараах зүйлсээр илэрхийлнэ (1.1.6.6). Үүнд:

- томъёоны өгөгдлийн талбар (1.1.6.6.1)
- хувьсах хэмжигдэхүүний нэрийн өгөгдлийн талбар (1.1.6.6.2)
- хувьсах хэмжигдэхүүний утгын өгөгдлийн талбар (1.1.6.6.3)

g) Өгөгдлийн хугацаатай (MNS ISO 14041:2001-ын 5.3.6-г үзэх) холбоотой байдлыг харуулахад хэрэглэх мэдээлэл буюу хүчинтэй хугацааны (1.1.7) цогц өгөгдлийн талбар. Үүнд:

- эхлэх өдрийн өгөгдлийн талбар (1.1.7.1)
- дуусах өдрийн өгөгдлийн талбар (1.1.7.2)
- хугацааны тодорхойлолтын өгөгдлийн талбар (1.1.7.3)

h) Өгөгдлийн газарзүйн байдлыг (1.1.8) харуулах мэдээлэл буюу хүчинтэй газарзүйн мэдээллийн цогц өгөгдлийн талбар. Үүнд:

- Газрын нэрийн өгөгдлийн талбар (7.3 нэрлэвэрийн 1.1.8.1)
- Газрын тодорхойлолтын өгөгдлийн талбар (1.1.8.2)
- Байршлын өгөгдлийн талбар (1.1.8.3)
- Газарзүйн мэдээллийн тогтолцооны заалтын өгөгдлийн талбар (7.3 нэрлэвэрийн 1.1.8.4)

i) Өгөгдлийг олох (1.1.9) асуудлыг үзүүлэхэд ашиглах мэдээлэл бүхий өгөгдлийн цуглуулалтын өгөгдлийн талбар ((MNS ISO 14041:2001-ын 5.3.6-ыг үзэх). Үүнд:

- Өгөгдөлд хамаарах хүн амаас үйл явцыг сонгох аргыг харуулах дээж авах горимын өгөгдлийн талбар (1.1.9.1)
- Дээж авах байршлын өгөгдлийн талбар (1.1.9.2)
- Байршлын тооны өгөгдлийн талбар (1.1.9.3)
- Дээжийн хэмжээний өгөгдлийн талбарыг дараах зүйлсээр илэрхийлнэ (1.1.9.4):
 - o Үнэмлэхүй өгөгдлийн талбар (1.1.9.4.1)
 - o Хамаарлын өгөгдлийн талбар (1.1.9.4.2)

5.2.3 Оролт, гаралт

Хэмжиж тооцоолсон буюу үнэлж, цуглуулсан өгөгдлийг үйл явцын оролт, гаралтын тоо хэмжээг тодорхойлоход ашиглана. Өгөгдлийг ангилж болох гол чиглэл нь дараах зүйлсийг багтаана. Үүнд:

- Эрчим хүчний, түүхий эд материалын, туслах болон бусад хөдөлгөөнт оролт
- Бүтээгдэхүүн
- Агаар, ус, хөрсний бохирдол ба байгаль орчны бусад асуудал

Эдгээр чиглэлийн дотор оролт гаралтыг судалгааны зорилгоор цааш нарийвчлан хуваана. (ISO 14041:1998, 4.4-ыг үзнэ үү).

Оролт, гаралтын баримтжуулалт нь дараах зүйлсийг агуулна.

- a) Дугаарын өгөгдлийн талбар (1.2.1)
- b) Чиглэлийн өгөгдлийн талбар (7.2 нэрлэвэрийн 1.2.2)
- c) Бүлгийн өгөгдлийн талбар (7.3 нэрлэвэрийн 1.2.1)
- d) Хүлээн авах орчны өгөгдлийн талбар (7.2 нэрлэвэрийн 1.2.4)
- e) Хүлээн авах орчны тодорхойлолтын өгөгдлийн талбар (7.3 нэрлэвэрийн 1.2.5)
- f) Хүлээн авах орчны нөхцлийн өгөгдлийн талбар (1.2.6)
- g) Газарзүйн байршлын өгөгдлийн талбар (1.2.7)
- h) Оролтын эх үүсвэр, гаралтын зориулалтыг харуулах гадаад тогтолцооны өгөгдлийн талбар (1.2.8). Үүнд:
 - o эх үүсвэр ба байрлалын өгөгдлийн талбар (1.2.8.1)
 - o тээврийн төрлийн өгөгдлийн талбар (1.2.8.1)
 - o мэдээллийн заалтын өгөгдлийн талбар (1.2.8.3)
- i) Оролт, гаралтын дотоод хэрэглээг товч харуулсан дотоод байршлын өгөгдлийн талбар (1.2.9)
- j) Оролт, гаралтын нэрийн цогц өгөгдлийн талбар (1.2.10):
 - нэрийн бичлэгийн өгөгдлийн талбар (1.2.10.1)
 - нэрлэвэрийн заалтын өгөгдлийн талбар (7.3 нэрлэвэрийн 1.2.10.2)
 - тоологдох тодорхойлолтын өгөгдлийн талбар (1.2.10.3)
- k) Шинж чанарын (1.2.11) цогц өгөгдлийн талбар:
 - нэрийн өгөгдлийн талбар (1.2.11.1)
 - нэгжийн өгөгдлийн талбар (7.3 нэрлэвэрийн 1.2.11.2)
 - дүнгийн өгөгдлийн талбар (7.3 нэрлэвэрийн 1.2.11.3)
- l) Дүнгийн (1.2.12) цогц өгөгдлийн талбар:
 - нэрийн өгөгдлийн талбар (7.3 нэрлэвэрийн 1.2.12.1)
 - нэгжийн өгөгдлийн талбар (1.2.12.2):
 - тэмдэг болон нэрийн өгөгдлийн талбар (7.3 нэрлэвэрийн 1.2.12.2.1)

MNS ISO/TS 14048:2004

- тайлбарын өгөгдлийн талбар (1.2.12.2)
- Хэмжигдэхүүний (1.2.12.3) өгөгдлийн талбар:
 - нэрийн өгөгдлийн талбар (7.3 нэрлэврийн 1.2.12.3.1)
 - утгын өгөгдлийн талбар (7.3 нэрлэврийн 1.2.12.3.2)
- m) Математик харьцааны (1.2.13) өгөгдлийн талбар:
 - томъёоны өгөгдлийн талбар (1.2.13.1)
 - хувьсах нэрийн өгөгдлийн талбар (1.2.13.2)
 - хувьсах утгын өгөгдлийн талбар (1.2.13.3)
- n) Оролт, гаралтаас илүү ихийг тодорхойлох баримтжуулалтын (1.2.14) өгөгдлийн талбар:
 - өгөгдөл цуглуулалтын өгөгдлийн талбар (1.2.14.1)
 - цуглуулсан өдрийн өгөгдлийн талбар (1.2.14.2)
 - өгөгдлийн боловсруулалтын өгөгдлийн талбар (1.2.14.3)
 - өгөгдлийн эх үүсвэрийн заалтын өгөгдлийн талбар (1.2.14.4)

5.3 Загварчлах, батлах

Загварчлах болон батлах гэсэн ойлголт нь загварын үр дүнг батлах зэрэг үйл явцыг загварчлах шаардлагыг тодорхойлно. Энэ нь үйл явцын асуудал болон ямар нэгэн шинж чанарыг үзүүлэхгүй. Үйл явцыг загварчлах үед ямар зарчмыг ашиглах, ямар таамаглал хийх зэрэгт янз бүрийн сонголт хийнэ. Өгөгдлийн ерөнхий чанар, холбоо нь эдгээр сонголт дээр үндэслэгдэнэ. Иймээс энэ баримт бичиг нь тусгай зорилго, хамрах хүрээний өгөгдлийн чанар, холбоог тайлбарлахад өгөгдлийг хэрэглэгчдэд туслана.

Загварчлах, батлах (2) үйл явц нь дараах асуудлыг хамарна.

- a) хэрэглээний өгөгдлийн талбар (2.1)
- b) мэдээллийн эх үүсвэрийн өгөгдлийн талбар (2.2)
- c) загварчлах зарчмын (2.3) өгөгдлийн талбар:
 - өгөгдлийг сонгох зарчмын өгөгдлийн талбар (2.3.1)
 - зохицуулах зарчмын өгөгдлийн талбар (2.3.2)
 - загварчлах тогтмол үзүүлэлтийн өгөгдлийн талбар (2.3.3)
 - нэрийн өгөгдлийн талбар (7.3 нэрлэвэрийн 2.3.3.1)
 - утгын өгөгдлийн талбар (2.3.3.2)
- d) Загварын сонголтын (2.4) цогц өгөгдлийн талбар
 - Энгийн урсгалд тавигдах шалгуурын өгөгдлийн талбар (2.4.1)
 - Завсарын бүтээгдэхүүний урсгалын шалгуурын өгөгдлийн талбар (2.4.2)
 - Гадаад үйл явцын шалгуурын өгөгдлийн талбар (2.4.3)
 - Тархалтын (2.4.3) өгөгдлийн талбар:
 - Тархалтын бүтээгдэхүүний өгөгдлийн талбар (2.4.4.1)
 - Тархалтын тайлбарын өгөгдлийн талбар (2.4.4.2)
 - Үйл явцын өсөлтийн (2.4.5) өгөгдлийн талбар:
 - Өсөлтөнд хамрагдах үйл явцын (2.4.5.1) өгөгдлийн талбар
 - Үйл явцын өсөлтийн өгөгдлийн талбар (2.4.5.2)
- e) Өгөгдлийн чанарын мэдээллийн өгөгдлийн талбар (2.5)
- f) Баталгаажуулалтын цогц өгөгдлийн талбар:
 - Аргачлалын өгөгдлийн талбар (7.3 нэрлэвэр 2.6.1/
 - Горимын өгөгдлийн талбар (2.6.2)
 - Үр дүнгийн өгөгдлийн талбар (2.6.3)
 - Баталгаа гаргагчийн өгөгдлийн талбар (2.6.4)
- g) Өгөгдлийг хэрэглэгчдэд өгөх зөвлөгөө зэрэг бусад мэдээлэлд зориулсан өгөгдлийн талбар (2.7)

5.4 Удирдлагын мэдээлэл

Удирдлагын мэдээлэл нь загвартай шууд хамааралгүй бөгөөд харин түүний баримтжуулалтын удирдлагатай холбоотой үйл явцын баримтжуулалтыг үзүүлнэ. Удирдлагын мэдээлэлд дараахь зүйлс хамаарна:

- a) Дугаарын өгөгдлийн талбар (3.1)
- b) Бүртгэлийн эрхийн өгөгдлийн талбар (3.2)
- c) Хэвлэлийн дугаарын өгөгдлийн талбар (3.3)
- d) Өгөгдөл хариуцагчийн өгөгдлийн талбар (3.4)
- e) Өгөгдлийн гаргагчийн өгөгдлийн талбар (3.5)
- f) Өгөгдлийн баримтжуулагчийн өгөгдлийн талбар (3.6)
- g) Өгөгдөл дуусгахад зориулсан өгөгдлийн нэг талбар (3.7)
- h) Хэвлэлтийн өгөгдлийн талбар (3.8)
- i) Зохиогчийн эрхийн өгөгдлийн талбар (3.9)
- j) Нэвтрэх хязгаарлалтын өгөгдлийн талбар (3.10)

6 Өгөгдлийн төрөл

Өгөгдлийн баримт бичгийн хэлбэрийн өгөгдлийн талбар бүр нь өгөгдлийг агуулагч болно. Өгөгдөл нь товч бичлэг, огноо, дэлгэрэнгүй бичлэг, тоо зэрэг янз бүрийн төрөл байж болно. Өгөгдлийн талбар дах өгөгдлийн төрлүүд нь хэрэглэгчдэд янз бүрээр ойлгогдохоос зайлсхийхийн тулд өгөгдлийн талбарын өгөгдлийн төрлүүдийг тодорхой ялгаж өгнө.

Өгөгдлийн төрөл нь өгөгдлийн талбар дах өгөгдлийн ерөнхий үзүүлэлтийг тодорхойлно. Өгөгдлийн төрлийн жишээ нь бүхэл тоо (бүхэл буюу энгийн тоо, бутархай бус, эерэг ба сөрөг тоо), шинж чанар (цагаан толгойн үсэг, аравтын бутархай тооны цифр, тусгай тэмдэглэгээ), цуваа (дараалсан үзүүлэлтийн цогц), бодит (зохистой болон зохисгүй тоо) байна.

Өгөгдсөн өгөгдлийн төрлийн хувьд түүний зөвшөөрөгдсөн утгын хэмжээг цувааны зөвшөөрөгдсөн урт гэх мэтээр тодорхойлох ба түүнийг хэлбэрийг огноог CCYY-MM-DD хэлбэртэй 10 цуваа тэмдэгтээр гэх мэтээр тодорхойлно.

Өгөгдлийн төрөл нь хэрэглэгчдэд өгөгдлийн загвар болон программ хангамжид оруулах заавар болох ба программ хангамжинд тогтмол ажиллуулах шаардлагатай.

1-р хүснэгт - Өгөгдлийн төрөл

Нэр	Төрөл	Тодорхойлолт
Огнооны хэлбэр	Цуваа	10 тэмдэгт; ISO 8601:2000, 5.2.1-д тодорхойлсноор CCYY-MM-DD
Огнооны давталтын хугацаа	Цуваа	17 тэмдэгт; ISO 8601:2000, 5.5-д тодорхойлсноор CCYYMMDD/CCYYMMDD
Чиглэл	Цуваа	Хамгийн ихдээ 24 тэмдэгт
Дэлгэрэнгүй бичлэг	Цуваа	Хэмжээ тодорхойгүй
Бүхэл тоо	Бүхэл тоо	-
Тэмдэг	Цуваа	Хамгийн ихдээ 150 тэмдэгт
Математик дүрэм	Цуваа	Хэмжээ тодорхойгүй.
Математик хувиргалт	Цуваа	Хамгийн ихдээ 150 тэмдэгт
Зураг	Цуваа	Хамгийн ихдээ 350 тэмдэгт. Цуваа нь зургийн файлын байрлалыг тодорхойлно.

MNS ISO/TS 14048:2004

Бодит	Бодит	-
Товч бичлэг	Цуваа	Хамгийн ихдээ 350 тэмдэгт

7 Нэрлэвэрийн сонголт

7.1 Ерөнхий зүйл

Ихэнх өгөгдлийн талбарт дэлгэрэнгүй бичлэг хэрэглэх боловч зарим өгөгдлийн талбарт тодорхой нэрлэвэр хэрэглэнэ. Өгөгдлийн баримтжуулалтын хэлбэр дэх нэрлэвэрийг дараах тохиолдолд хэрэглэнэ:

a) нэр томъёог хоёрдмол утгагүй, нэг юм уу цөөн үгээр илэрхийлсэн, тодорхой байна.

Жишээ: Оролт, гаралт – Дүн – Нэгж, Си-нэгж г.м

b) нэр томъёо нь өгөгдлийг хооронд нь ялгахад туслах тайлбарыг үзүүлнэ.

Жишээ: Оролт, гаралт – “бохирдол”, “бүтээгдэхүүн” зэрэг бүлэг г.м

c) Нэр томъёо эсвэл код нь нэр томъёо, кодын тайлбарыг хоёрдмол утгагүйгээр харуулсан байна.

Жишээ: CAS дугаар буюу улсын код

Дараах гурван төрлийн нэрлэвэрийг өгөгдлийн баримт бичгийн хэлбэрт хэрэглэнэ:

- тусгай нэрлэвэр
- нийтлэг нэрлэвэр
- хэрэглэгчийн тодорхойлсон нэрлэвэр

Тусгай нэрлэвэрийг хэрэглэгчид өргөнөөр хэрэглэхгүй бөгөөд зөвхөн тодорхой нэр томъёонд хүчинтэй.

Нийтлэг нэрлэвэрийг тодорхой шаардлагаар өгөгдлийн баримт бичгийн хэлбэрийг хэрэглэгчид өргөнөөр хэрэглэнэ.

Хэрэглэгчийн тодорхойлсон нэрлэвэрийг хэрэглэгчдийн шаардлагатай гэж үзсэн өгөгдлийн баримт бичгийн хэлбэрийн өгөгдлийн талбарт хэрэглэнэ.

7.2 Тусгай нэрлэвэр

Дараах тогтсон тусгай нэрлэвэр байна:

a) Үйл явцын тодорхойлолт – Нэгтгэсэн төрөл

Жишээ: Нэгтгээгүй, хөндлөнгөөр нэгтгэсэн, босоогоор нэгтгэсэн, хөндлөнгөөр болон босоогоор нэгтгэсэн, тодорхой бус

b) Оролт, гаралт – Чиглэл

Жишээ: оролт, гаралт, урсгалтай холбоогүй асуудал

c) Оролт, гаралт – Хүлээн авах орчин

Жишээ: Агаар¹⁾, Ус²⁾, Газар³⁾

7.3 Нийтлэг нэрлэвэр

Дараах нийтлэг нэрлэвэрийг хэрэглэхийг зөвлөнө:

a) Үйл явцын тодорхойлолт – Тоологдох тодорхойлолт – Төрөл

Жишээ: Үйл явцын стандарт урсгал, гаралтын бүтээгдэхүүний урсгал, оролтын бүтээгдэхүүний урсгал, бусад урсгал, үйлдвэрлэх хугацаа, бусад хэмжигдэхүүн, үйл ажиллагааны нэгж

b) Үйл явцын утга – Техникийн хамрах хүрээ

Жишээ: өлгий-хаалга, өлгий-булш, хаалга-хаалга, хаалга-булш

Үйл явцын янз бүрийн төрөлд зориулсан нэрлэвэрийг амьдралын мөчлөгийн үнэлгээнд үзүүлсэн янз бүрийн үйл явцын дагуу хийнэ. Техникийн хүрээний нэрлэвэрийн утгыг доор үзүүлэв:

- 1) өлгий-хаалга: дараагийн бүх үе шатыг бус, зарим үйлдвэрлэл, үйлчилгээний үйл ажиллагааг хамарсан нөөцийн эх үүсвэрээр эхлүүлэх үйл явц
- 2) өлгий - булш: бүтээгдэхүүний эцсийн шатны нөөцийн эх үүсвэрээр эхлүүлэх үйл явц
- 3) хаалга – хаалга: нэг байршилд бүх үйлдвэрлэл явагдах үйл явц. Байршил нь газар зүйн байдлаар тодорхойлогдох буюу ихэнх тохиолдолд газарзүйн тодорхойлолт нь өргөн байна. Тодорхойлсон хаалганаас гадуур үйл явцыг хамруулахгүй.
- 4) Хаалга – булш: бүтээгдэхүүнийг эцсийн шатанд байрлуулах, ашиглах, түгээх үйл явц.

Тайлбар: Дахин боловсруулсан материалыг хэрэглэх буюу тухайн системээс материал үлдэх тохиолдолд үйл явцад энэ нэрлэвэрийг ашиглахгүй.

c) Үйл явцын тодорхойлолт - Газар нутаг – Газрын нэр. Alpha –2 –ын кодыг ISO 3166-1 стандартыг үзнэ үү.

d) Үйл явцын тодорхойлолт - Газар нутаг – GIS стандарт. ISO 6709 стандартыг үзнэ үү.

e) Оролт ба гаралт – Бүлэг

Жишээ: Нөөц, түүхий эд материал, эрчим хүч, дулаан ялгаруулалт, тунадас, бүтээгдэхүүн

Бүлгийн ангилалын утгыг дор үзүүлсэн:

1. Нөөц: Энерги, эрдэс зэрэг байгалийн нөөц баялаг
2. Түүхий эд материал: завсрын бүтээгдэхүүн, хагас бэлэн бүтээгдэхүүн зэрэг техносферээс гарсан оролтын түүхий эд материал
3. Энерги: техносферээс гарсан оролтын эрчим хүч
4. Туслах материал: материал, тээвэрлэлтийн урсгал, бусад үйлчилгээ
5. Дулаан ялгаруулалт: Байгалийн дулаан
6. Тунадас: Хатуу, шингэн, хийн урсгал
7. Бүтээгдэхүүн: Үйлдвэрлэлийн бүтээгдэхүүн (үйлчилгээ, тээвэр зэрэг)
8. Бүтээгдэхүүн: Үйлдвэрлэлийн бүтээгдэхүүн (үйлчилгээ, тээвэр зэрэг)

f) Оролт, гаралт – Хүлээн авах орчны тодорхойлолт

Жишээ: Хөдөө аж ахуйн, ойн, маш өндөр (>1 000 м), тасалгааны, хөдөөний болон хотын агаар, хөдөө аж ахуйн, ойн, ногооны, үйлдвэрийн, хөдөөний болон хотын газар, горхи, эрдэсжсэн ус, гүний ус, нуур, намаг, далай, цөөрөм, далайн эргийн ус, далайн эргийн газар, гадаргуун ус, намаг, хүрхрээ, техносфер

MNS ISO/TS 14048:2004

g) Оролт, гаралт – Нэр - Нэрлэвэрийн тодорхойлолт: CAS тоо, SETAC нэрлэвэр

h) Оролт, гаралт – Дүн – Нэр

Жишээ: Утга, шинж тэмдэг, хэмжээ, чиглэл

i) Оролт, гаралт – Дүн – Нэгж- Тэмдэг буюу нэр

Жишээ: ISO 31-д заасан нэгжийн олон улсын систем (Си)

j) Оролт, гаралт – Дүн – Хэмжигдэхүүн- Нэр

Жишээ: хувиралтын коэффициент, их утга, утга, дундаж шугам, бага утга, жишиг хэмжээ, стандарт хазайлт, дундаж алдаа

k) Загварчлах, батлах – Загварлах зарчим – Загварлах тогтмол – Нэр

Жишээ: цэвэр дулааны утга, нийт дулааны утга, дахин боловсруулалтын хувь, үйл явцын бүтээмж, үр ашгийн хувь, тээвэрлэх зай

l) Загварчлах, батлах – Батлах – Арга

Жишээ: Газар дээр нь баталгаажуулах, дахин тооцоолох, их хэмжээний үлдэгдэл, бусад эх үүсвэрийг дахин шалгах, өгөгдлийн оруулалтыг шалгаж унших

m) Нэгж (хэд хэдэн газарт гарна)

Жишээ: ISO 31-д заасан нэгжийн олон улсын систем (Си)

Си нэгжийг хаана ч ашиглах боломжтой. “торх”, “бушель”, “галлон”, “чимх”, “миль”, “фунт”, “тонн” зэрэг нь Си нэгжид орохгүй учир хэрэглэхийг хориглоно.

А хавсралт (Норматив)

Өгөгдлийн баримт бичгийн хэлбэрийн нарийвчилсан тодорхойлолт

А.1 Ерөнхий зүйл

Энэ хавсралт нь янз бүрийн өгөгдлийн талбарын хэлбэрийн шаардлага болон ашигласан ойлголтын тухай тайлбар зэрэг өгөгдлийн баримт бичгийн хэлбэрийн нарийвчилсан тодорхойлолтыг үзүүлнэ. Нэмж хэлэхэд, энэ техникийн тодорхойлолтод үндэслэсэн электрон өгөгдлийн солилцооны хэлбэрийг хэрэгжүүлэх шаардлагыг А.3-д үзүүлсэн.

А.1, А.2-р хүснэгтэд өгөгдлийн талбарын нэр, өгөгдлийн тодорхойлолтыг үзүүлсэн. Нэр томъёо бүрийн өгөгдлийг тусдаа багананд харуулна. Өгөгдлийн төрлийн тодорхойлолтыг 6-р бүлэгт тусгасан. Нэрлэвэрийг хэзээ өгөгдлийн талбарт тодорхойлохыг харуулахын тулд нэрлэвэрийн баганыг ашиглана. Нэрлэвэрийг 7-р бүлэгт тодорхойлсон. Бусад өгөгдлийн талбарт хэрэглэгчдийн тодорхойлсон нэрлэвэрийг хэрэглэх боломжтой. Өгөгдлийн талбар бүрийн хувьд зөвшөөрөгдсөн тоог холбогдох ойлголт дах түүний хамааралыг тодорхойлохын тулд үзүүлнэ. Хүснэгт дэх зураастай нүд нь тухайн нүдийг хэрэглэх боломжгүйг харуулна.

А.2 Өгөгдлийн баримт бичгийн хэлбэрийн тодорхойлолт

А.2.1 Ерөнхий зүйл

Өгөгдлийн баримт бичгийн хэлбэр нь дараах гурван хэсгээс бүрдэнэ:

- **Үйл явц:** Технологи, цаг хугацаа, газарзүйн г.м мэдээлэл (Үйл явцын тодорхойлолт) ба түүний тоон хэмжигдэхүүн (оролт, гаралт)-тэй холбоотой загварчлах үйл явцын шинж чанарын тодорхойлолт
- **Загварчлах, батлах:** Үйл явцын загварчлал, батлах шаардлага
- **Удирдлагын мэдээлэл:** Үйл явцын баримтжуулалтын удирдлагатай холбоотой мэдээлэл

А.2.2 Үйл явц

Үйл явцын тодорхойлолтыг 5.2-т үзүүлсэн.

А.1-р хүснэгт - Үйл явц

Тайлбарын №	Өгөгдлийн талбар	Тодорхойлолт	Өгөгдлийн төрөл	Нэрлэвэр	Зөвшөөрөгдөх тоо
1.	Үйл явц		-	-	Нэг
1.1	Үйл явцын тодорхойлолт	Үйл явцын тодорхойлолтыг нэр, ангилалын систем дэх түүний байрлал, өгөгдөлд хамаатай заалтын дугаар, үйл явцын нийт түвшин, техникийн хүрээгээр тодорхойлно. Үйл явцын технологи, түүний үйл ажиллагааны нөхцөл, хугацаа ба газарзүй болон өгөгдлийн оруулах нарийвчилсан зүйлсийг хамруулах нь чухал. Өгөгдлийн тодорхойлолтыг 5.2.2-д үзүүлсэн.	-	-	Нэг
1.1.1	Нэр	Үйл явцын тодорхойлолтын нэр. Жишээ: “Дулаан ба эрчим хүчний үйлдвэр” эсвэл “Хүнд ачааны машинаар хол газар тээвэрлэлт хийх” г.м	Тэмдэг	Үгүй	Нэг
1.1.2	Ангилал	Ангилал нь өгөгдлийг тодорхойлох, хайхад хялбар болгоно. Ангилал нь нэртэй харьцуулахад хэрэглэгчдэд сонирхсон өгөгдөлд хялбар нэвтрэхүйц хоёрдмол утгагүй тодорхой бүтэцтэй болгоно. Аливаа үйл явцад хэд хэдэн ангилалыг ашиглах боловч ангилал бүрд үйл явц нь тухайн ангиллын зөвхөн нэг нэрэнд хамаарагдана. (Ангиллын дүрмийг уг баримт бичигт боловсруулаагүй.) Ангиллын нэрийг 1.1.2.1 болон 1.1.2.2-д үзүүлсэн.	-	-	Хязгааргүй
1.1.2.1	Нэр	Баримтжуулсан хэрэглэгчийн тодорхойлсон нэрлэвэрээс авсан ангилалд хамаатай үйл явцын нэрийн тодорхойлолт.	Тэмдэг	Тийм	Нэг
1.1.2.2	Нэрлэвэрийн тодорхойлолт	Нэрийг сонгосон нэрлэвэрийн тодорхойлолт.	Товч бичлэг	Үгүй	Нэг
1.1.3	Тоологдох тодорхойлолт (заалт)	Үйл явцын хувьд тоологдох тодорхойлолт нь үйл явцад хамаарах оролт, гаралтын хэмжээтэй холбоотой тодорхойлолт юм. Жишээ: Бусад үйл явцын оролт, гаралт болох үйл ажиллагааны нэгж (1тн*км) эсвэл заалтын урсгал (1 кВцаг цахилгаан). Энэ нь үйл явцын оролт, гаралтын аль нэгтэй адил эсхүл өөр байж болох тохиолдол бий. Тоологдох тодорхойлолтыг 1.1.3.1, 1.1.3.4-д үзүүлсэн.	-	-	Нэг
1.1.3.1	Төрөл	Тоологдох тодорхойлолтын төрөл. Жишээ: Үйл ажиллагааны нэгж, үйл явцын стандарт урсгал, бусад урсгал	Товч бичлэг	Тийм	Нэг

1.1.3.2	Нэр	Тоологдох тодорхойлолтын нэр	Товч бичлэг	Үгүй	Нэг
1.1.3.3	Нэгж	Тоологдох тодорхойлолтын нэгж	Товч бичлэг	Тийм	Нэг
1.1.3.4	Дүн	Тоологдох тодорхойлолтын дүн	Бодит	Үгүй	Нэг

А.1-р хүснэгт (үргэлжлэл)

№	Өгөгдлийн талбар	Тодорхойлолт	Өгөгдлийн төрөл	Нэрлэвэр	Зөвшөөрөгдөх хэмжээ
1.1.4	Техникийн салбар	Нэрлэвэр ашигласан өгөгдлийн нэр томъёогоор илэрхийлсэн үйл явцын техникийн салбарын талаархи товч тодорхойлолт. Энэ нь бүтээгдэхүүний амьдралын мөчлөгийг хамруулсан нэг юм уу хэд хэдэн үйл явц байж болно. Жишээ: хаалга-хаалга, өлгий-булш	Товч бичлэг	Байна	Нэг
1.1.5	Нэгтгэлийн төрөл	Ижил үйл ажиллагаагаар хангах хэд хэдэн үйл явцын дундаж (хэвтээ), эсвэл нэрлэвэрээр үзүүлсэн хоорондоо холбоотой үйл явцын нийлбэр (босоо)-ийг үзүүлэх гэх мэт нэгтгэсэн нэгж үйл явцыг тодорхойлоход ашиглана.	Тэмдэг	Байна	Нэг
1.1.6	Технологи	Үйл явцын технологийн хэрэглээний баримтжуулалт. Энэ нь өгөгдлийн хэрэглэгчдэд загварын техникийн хамаарлыг үнэлэхэд тусална. Баримтжуулалтыг 1.1.6.1 болон 1.1.6.4-д үзүүлнэ.	-	-	Нэг
1.1.6.1	Технологийн товч тодорхойлолт	Технологийн тухай товч тодорхойлолт. Тайлбар: Технологийн бүрэн хэмжээний тодорхойлолтыг 1.1.6.2-ын Техникийн агуулга, үйл ажиллагаанд үзүүлсэн.	Товч бичлэг	Үгүй	Нэг
1.1.6.2	Техникийн салбар, үйл ажиллагаа	Үйл ажиллагаа болон тэдгээрийн техникийн болон материаллаг байдлаар хэрхэн холбогдох тухай нарийвчлан үзүүлсэн тодорхойлолт. Өгөгдлийг нэгтгэх ба нэгтгэх үйл явцыг үзүүлээгүй үед нэгтгэх үйл явцын тодорхойлолтыг энд үзүүлнэ. Нэгдсэн үйл явцын жишээ: ISO 14041 :1998-ын 6.4.4-д үзүүлсэн өгөгдлийн нэгтгэлийн үр дүн	Дэлгэрэнгүй бичлэг	Үгүй	Нэг
1.1.6.3	Технологийн зураг	Технологийн графикан үзүүлэлт. Жишээ: Үйл явцын графикан бүдүүвч.	Зураг	-	Нэг

MNS ISO/TS 14048:2004

		Энэ нь 1.1.6.2-ын Техникийн агуулга, үйл ажиллагааны өгөгдлийн талбар дах технологийн тодорхойлолтонд нэмэлт болно.			
1.1.6.4	Үйл явцын хамрах хүрээ	Нэгтгэсэн үйл явц бүрд баримтжуулалт хийх, нэгж үйл явцын нэгдлээс бүрдэх үйл явц. Нэгдлийн үйл явц нь ISO 14041:1998-ын 6.4.4-д үзүүлсэн өгөгдлийн нэгтгэлийн үр дүн	-	-	Нэг
1.1.6.4.1	Хамрагдах үйл явц	Хамрагдах үйл явц бүрийн удирдлагын мэдээлэл дэх тодорхойлолтын тооны хоёрдмол утгагүй тайлбар 1.1.6.4.1 болон 1.1.6.4.2-д үйл явцын хэмжээг үзүүлсэн.	Тэмдэг	Үгүй	Хязгааргүй
1.1.6.4.2	Завсрын бүтээгдэхүүний урсгал	Хоёр үйл явцын хоорондох оролт, гаралтын хоёрдмол утгагүй заалт Заалтыг 1.1.6.4.2.1-1.1.6.4.2.4-д үзүүлсэн.	-	-	Хязгааргүй
1.1.6.4.2.1	Эх үүсвэрийн үйл явц	Эх үүсвэр зэрэг үйл явцын удирдлагын мэдээлэл дэх тодорхойлох дугаарын заалт	Тэмдэг	Үгүй	Нэг
1.1.6.4.2.2	Оролт, гаралтын эх үүсвэр	Эх үүсвэрийн урсгал зэрэг оролт, гаралтын үйл явцын тайлбар (Үйл явцын оролт, гаралтын тодорхойлох заалтаар тогтоосон)	Бүхэл тоо	Үгүй	нэг
1.1.6.4.2.3	Оролт, гаралтын байрлал	Байрлалын урсгал зэрэг оролт, гаралтын үйл явцын заалт (Үйл явцын оролт, гаралтын тодорхойлох заалтаар тогтоосон)	Бүхэл тоо	Үгүй	Нэг
1.1.6.4.2.4	Байрлалын үйл явц	Байрлал зэрэг үйл явцын удирдлагын мэдээлэл дэх тодорхойлох дугаарын заалт	Тэмдэг	Үгүй	Нэг
1.1.6.5	Үйл ажиллагааны нөхцөл	Үйл явцын үйл ажиллагааны нөхцлийн заалт. (Боломжтой бол шулуун биш) оролт, гаралтын бодит холбоо	Дэлгэрэнгүйбичлэг	Үгүй	Нэг
1.1.6.6	Математик загвар	Математик загварчлалын үйл явцад үйл ажиллагааны нөхцлийг оролт, гаралтын хоорондын математик загварчлалаар баримтжуулж болно.	-	-	Нэг
1.1.6.6.1	Томъёо	Математик загварчлал дах томъёоны тодорхойлолт. Нэг эсхүл хэд хэдэн томъёо хэрэглэж болно.	Математик дүрэм	Үгүй	Хязгааргүй
1.1.6.6.2	Хэмжигдэхүүний нэр	Хэмжигдэхүүний нэрийг томъёонд ашиглана. Нэг эсхүл хэд хэдэн хэмжигдэхүүнийг тодорхойлж болно.	Математик дүрэм	Үгүй	Хязгааргүй

1.1.6.6.3	Хэмжигдэхүүний утга	Хэмжигдэхүүний утгыг томъёонд ашиглана. Утга нь тодорхойлсон хэмжигдэхүүн бүр дээр хэрэгжинэ.	Бодит	Үгүй	Хязгааргүй
1.1.7	Хүчинтэй хугацаа	Үйл явцын загвар хүчинтэй байх хугацааны тодорхойлолт. Төсөл, урьдчилсан мэдээллийг хэрэглээгүй бол хүчинтэй хугацаа нь өгөгдлийг цуглуулах хугацаатай ижил байна. Тайлбар: Хүчинтэй хугацаа нь өгөгдлийг хэвлэх хугацаа биш. Хугацааг 1.1.7.1, 1.1.7.2 болон 1.1.7.3-д тайлбарласан.	-	-	Нэг
1.1.7.1	Эхлэх өдөр	Хүчинтэй хугацаа эхлэх өдөр	Өгөгдлийн хэлбэр	Үгүй	Нэг
1.1.7.2	Дуусах өдөр	Хүчинтэй хугацаа дуусах өдөр	Өгөгдлийн хэлбэр	Үгүй	Нэг
1.1.7.3	Хугацааны тодорхойлолт	Үйл явцын загварын хүчинтэй хугацааны тодорхойлолттой ижил чөлөөт хугацааны тодорхойлолт	Дэлгэрэнгүй бичлэг	Үгүй	Нэг
1.1.8	Газар зүйн байдал	Тухайн үйл явц болон өгөгдөлд хамаарах байршил, газарзүйн тодорхойлолт. Энэ нь өгөгдлийг цуглуулах байршил, талбайтай ижил байна. Газар нутгийн хэмжээг 1.1.8.1-аас 1.1.8.4-д баримтжуулсан.	-	-	Нэг
1.1.8.1	Газрын нэр	Газар буюу байршлын нэг эсхүл түүнээс олон нэр	Товч бичлэг	Байна	Хязгааргүй
1.1.8.2	Газрын тодорхойлолт	Газарзүйн байршлын ерөнхий тодорхойлолт Жишээ: Өгөгдөл нь зөвхөн тодорхой нэг муж, улс, хотод хүчинтэй, эсхүл тодорхой газарт хамаарахгүй байх эсэх	Дэлгэрэнгүй бичлэг	Үгүй	Нэг
1.1.8.3	Байршил	Байршлыг хамарсан тодорхой нэг юм уу түүнээс олон хаяг	Товч бичлэг	Үгүй	Хязгааргүй
1.1.8.4	Газарзүйн мэдээллийн тогтолцооны заалт	Газарзүйн мэдээллийн тогтолцоонд тодорхойлсон нэг буюу түүнээс олон газар зүйн мэдээллийн тогтолцооны заалт. Газар зүйн мэдээллийн тогтолцооны тайлбар нь тойрог, шулуун өнцөгт, цэг зэрэг бүсд хамаарна.	Тэмдэг	Тийм	Нэг
1.1.9	Өгөгдлийг олох	1.1.9.1-ээс 1.1.9.4-д, үйл явцын түвшинд өгөгдлийг цуглуулалт, засварлалтын баримтжуулалт	-	-	Нэг
1.1.9.1	Дээж авах горим	Өгөгдөл хүчинтэй үйл явцыг	Дэлгэрэн-	Үгүй	Хязгаар

MNS ISO/TS 14048:2004

		сонгох арга	гүй бичлэг		гүй
1.1.9.2	Дээж авах байршил	Дээж авсан байршлын хаяг	Товч бичлэг	Үгүй	Нэг
1.1.9.3	Байршлын тоо	Өгөгдсөн өгөгдлийн хоёрдмол байдлыг тайлбарлах мэдээлэл болох дээж авсан байршлын тоо	Бодит	Үгүй	Нэг
1.1.9.4	Дээжийн хэмжээ	1.1.9.4.1 болон 1.1.9.4.2-д үзүүлсэн үйл явцын үйлдвэрлэлийн хэмжээ	-	-	Нэг
1.1.9.4.1	Үнэмлэхүй	Дээж авсан байршлын нийт үйлдвэрлэлийн хэмжээ	Товч бичлэг	Үгүй	Нэг
1.1.9.4.2	Хамаарал	Өгөгдөл хүчинтэй байх нийт үйлдвэрлэлийн хэмжээний хувь Тайлбар ISO 14041:1998 (5.3.6)-д гол өгөгдлийг тайлагнах байршлын хувийг ашиглах бол ISO 14043-д өөрөөр хэрэглэнэ. Иймд дээж авах хэмжээ нэр томъёог энэ баримт бичигт ашигласан.	Бодит	Үгүй	Нэг
1.2	Оролт, гаралт	5.2.3-д заасан оролт, гаралтын тодорхойлолт.	-	-	Хязгаар гүй
1.2.1	Дугаар	Тусгай оролт, гаралтыг тодорхойлох өгөгдлийн хадгалалт ба шилжүүлэлтийн дугаар.	Бүхэл тоо	Үгүй	Нэг
1.2.2	Чиглэл	Оролт, гаралтын чиглэл. Чиглэл нь нэрлэвэр байна.	Удирдлага	Байна	Нэг
1.2.3	Бүлэг	Оролт, гаралтын хамаарагдах бүлэг. Үүнд: Нөөц, түүхий эд материал, дулаан, бүтээгдэхүүн. Үйл явцын бүлэг нь янз бүрийн оролт, гаралтын үүргийг тодорхойлно. Бүлэг нь нэрлэвэр байна.	Тэмдэг	Байна	нэг
1.2.4	Хүлээн авах орчин	Оролт, гаралтыг хэрхэн дамжуулахыг тодорхойлох тусгай нэрлэвэр. Энгийн бус оролт, гаралтын хувьд хүлээн авах орчин нь бусад үйл явцтай холбогдох оролт, гаралтыг тодорхойлох техносфер байна. Энгийн оролт, гаралтын хувьд энгийн нэрлэвэр нь нөөц, дулаан ялгаруулалт, ус, хөрс, агаар зэрэг орчны төрлийг тодорхойлно. Энгийн урсгалын хувьд энэ нэрлэвэр нь ISO 14042-д үзүүлсэн нөлөөллийн үнэлгээ болон концентрацийг тооцоолоход шаардлагатай мэдээлэл болно.	Тэмдэг	Байна	Нэг
1.2.5	Хүлээн авах орчны тодорхойлолт	Оролт, гаралтад нөлөөлөх орчны төрлийг тодорхойлох нийтлэг нэрлэвэр. Энгийн бус оролт, гаралтын хувьд	Тэмдэг	Байна	Нэг

		хүлээн авах орчны тодорхойлолт нь оролт, гаралт нь нөлөөллийн үнэлгээнд хамаарахгүй байхыг илэрхийлэх “техносфер” байна. Энгийн оролт, гаралтын хувьд нийтлэг нэрлэвэр нь үзүүлэлтийг загварчлахад эхлэх орчны нөхцлүүдийн хоорондын ялгааг үзүүлнэ. Энэ мэдээлэл нь ISO 14042-д үзүүлсэн нөлөөллийн үнэлгээг сайжруулж болно.			
1.2.6	Орчны нөхцөл	Хүлээн авах орчин болон түүний тодорхойлолтод заасан орчны нөхцлийг чөлөөт бичлэгээр үзүүлсэн тодорхойлолт	Дэлгэрэнгүй бичлэг	Үгүй	Нэг
1.2.7	Газарзүйн байршил	Үйл явц, оролт, гаралтын газарзүйн байршлын талаархи мэдээлэл. Энэ тодорхойлолт нь янз бүрийн газарзүйн байршил дах оролт, гаралтын хэмжээ болон янз бүрийн орчинд ашиглана.	Товч бичлэг	Үгүй	Нэг
1.2.8	Гадаад тогтолцоо	Гадаад байдалд хамаарах тогтолцооны мэдээлэл. Үүнд: Амьдралын мөчлөгийн үнэлгээний судалгаанд ашиглах баримт бичигт үйл явцыг үзүүлсэн үед дээд ба доод урсгалын үйл явцыг тодорхойлно. Жишээ: Хаягдал усыг хүлээн авах урсгал усны үйлдвэрийн төрөл эсхүл тээвэрлэлтийг тусгай үйл явц шиг тайлагнаагүй үед тээвэрлэлтийн зайг тооцоолох боломжтой түүхий эд материалын нийлүүлэгчийн нэр, байршил. Тайлбар: Гадаад байдалд хамаарах тогтолцоо нь үйл явцад хамаарахгүй. Тодорхойлолтыг 1.2.8.1-ээс 1.2.8.3-д үзүүлсэн.	-	-	Нэг
1.2.8.1	Эх үүсвэр ба байрлал	Завсарын бүтээгдэхүүний урсгалыг дамжуулах буюу хүлээн авах үйл явц (дээд ба доод)-ын газарзүйн тодорхойлолт	Товч бичлэг	Үгүй	Нэг
1.2.8.2	Тээврийн төрөл	Тээврийн хэрэгсэл нийлүүлэгчийн нэр эсхүл тээврийн төрөл	Товч бичлэг	Үгүй	Нэг
1.2.8.3	Мэдээллийн заалт	Холбогдох гадаад тогтолцооны мэдээллийг хамруулсан бусад баримт бичиг буюу харилцагч	Товч бичлэг	Үгүй	Нэг

		хүмүүстэй холбогдох заалт			
1.2.9	Дотоод байршил	Үйл явцын оролт, гаралтыг ашиглах тухай мэдээлэл. Үүнд: Үйл явцын тусгай хэрэглээнд урсгалыг ашиглах г.м	Дэлгэрэнгүй бичлэг	Үгүй	Нэг
1.2.10	Нэр	Оролт, гаралтын нэр. Байгаль орчны бусад асуудал буюу оролт, гаралтын зүйлсийг тодорхойлох зорилгоор хоёрдмол утгагүйгээр нэрлэх хэрэгтэй. Энэ нь өгөгдлийг харилцан мэдээлэх болон тайлагнах үед өгөгдөл хүлээн авагчийн тодорхойлсон нэрийн хувьд шүүмжлэлтэй байна. Энэ нэрийг 1.2.10.1-ээс 1.2.10.3-д тодорхойлсон.	-	-	Нэг
1.2.10.1	Нэрийн бичлэг	Утга агуулгын нэрс	Тэмдэг	Байна	Нэг
1.2.10.2	Нэрлэвэрийн тайлбар	CAS-гишүүн, SETAC-нэрлэвэр гэх мэт утга агуулгын нэрийн сонголтын нэрлэвэр.	Товч бичлэг	Байна	Нэг
1.2.10.3	Нэрийн тодорхойлолт	Нэрийг ойлгоход шаардлагатай нэрийн тухай тодорхойлолт	Товч бичлэг	Үгүй	Нэг
